

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛЭНД ХҮНИЙ НЭР БҮТЭЭЖ БУЙ
ХЭЛЗҮЙН АРГУУД

Ж.Сэржээ¹

Монгол хүний нэр болон хэрэглэгдэж байгаа үгсийг утга зүйн талаас нь урьд өмнө судалсан бүтээлүүдэд тэдгээр үгийн зөвхөн үгийн сангийн утгыг нь анхааран үзэж, ан амьтны нэрээр нэрлэсэн, ургамлын нэрээр нэрлэсэн, од гаригийн нэрээр нэрлэсэн, гэр ахуйн эдлэл хэрэглэлийн нэрээр нэрлэсэн нэр гэх буюу эсвэл, амар амгалан эрүүл энхийг хүссэн утгатай, аз жаргал баяр баясгалантай явахыг хүсэн ерөөсөн утгатай, элбэг баян урт удаан наслахыг ерөөсөн утгатай нэр гэх мэтчилэн ангилсаар өнөө хүрч байна. Тэгвэл оноосон нэрийн судалгааг хэлний янз бүрийн төвшинд хийж болдгийг өнөөгийн нэр зүйн судалгааны ололтууд харуулж эхлэв. Зөвлөлтийн нэр зүйч эрдэмтэн, доктор, профессор А. В. Суперанская «Оноосон нэрийн судалгааг авиазүйн төвшинөөс эхлээд авиалбар зүй, үг зүй, үгийн сан, бүр өгүүлбэр зүйн төвшин хүртэл хэлний янз бүрийн төвшинд хийж болно» / А. В. Суперанская. 1969. 11-р тал/ гээд өөрөө энэ талаар багагүй судалгаа хийж «Оноосон нэрийн бүтэц» (авиа зүй ба үг зүй) гэдэг ном бичжээ. А. В. Суперанскаягийн энэхүү онолын үндсэн дээр орчин цагийн монгол хүний нэрийн 70% гаруйг эзэлж байгаа нийлмэл нэрийн бүтцийг үг зүй-өгүүлбэр зүйн талаас нь нарийвчлан үзсэн юм. Өөрөөр хэлбэл монгол хүний нийлмэл нэрийн бүрэлдэхүүнд орж байгаа үгс нь өөр хоорондоо ямар харьцаатай, хэл зүйн ямар утга илэрхийлдэгийг нь тодорхойлохыг зорьсон юм.

Орчин үеийн хэл шинжлэл дэх “хэл зүйн утга гэдэг нь тухайн үгийн үгийн сангийн утгад нэмэлт болж, янз бүрийн харьцааг (бусад үг, холбоо үг, өгүүлбэрт харьцах харьцаа, үйл явдлыг үйлдэгчид болон бусад бие харьцах харьцаа хийгээд яригч мэдээлэгч хоёрын харьцаа гэх мэт) илэрхийлдэг утга юм” /Д.Э.Розенталь, М.А Теленкова 1986. 59-р тал/ Хэл зүйн утга нь үг зүйн болон өгүүлбэр зүйн аргаар хэлэнд илэрдэг. Монгол хэлний хувьд хэл зүйн утга ихэвчлэн холбоо үг, өгүүлбэр дэх үгсийн байр, үгийн хэлбэрээр илэрдэг. Орчин үеийн монгол хүний N+N бүтэцтэй нийлмэл нэрийг бүрэлдүүлж буй гишүүдийнх нь хоорондох харьцааг үндэслэн утга зүйн талаас нь 1. зэрэгцүүлсэн холбоостой нийлмэл нэр; 2. захируулсан холбоостой нийлмэл нэр гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваан үзэж болно. /Ж.Сэржээ, 1992. 26-27-р тал/

1. Зэрэгцүүлсэн холбоостой нийлмэл нэр

Зэрэгцүүлсэн холбоостой нийлмэл нэрийн бүрэлдэхүүнд орж байгаа хоёр үг нь бие биеэ захираагүй, бие биеэсээ хараат бус шинжтэй байх бөгөөд ихэвчлэн үгийн нэгэн аймгийн үг байдаг. Жишээлбэл: Ганболд (хоёулаа бодит нэр), Буянхишиг (хоёулаа хийсвэр нэр), Байгальдэлхий (хоёулаа бодит нэр) гэх мэт. Эдгээр нийлмэл нэрийн бүрэлдэхүүнд орж байгаа үгс нэг нь нөгөөдөө захирагдаагүй тэгш эрхтэй учир байрыг нь солиход ч тэдгээрийн хоорондох

1. Монгол Улсын Их Сургууль

харьцааны утга өөрчлөгддөггүй. Жишээлбэл: Батбэх, Бэхбат, Амармэнд, Мэнд-Амар, Батмөнх, Мөнхбат, Буян-Өлзий, Өлзийбуян, Тэгшбүрэн Бүрэнтэгш гэх мэт.

2. Захируулсан холбоостой нийлмэл нэр

Нийлмэл нэрийн бүрэлдэхүүнд орж байгаа үгсийн аль нэг нь голлох үүрэгтэй байж, нөгөөгөө эрхшээн захирсан байх бөгөөд нөгөө нь түүндээ захирагдаж, утга санааг нь дэлгэрүүлэн тодотгосон байдаг нэрийг захируулсан холбоостой нийлмэл нэр гэж нэрлэв. Захируулсан холбоостой нийлмэл нэрийг дотор нь 1. тодотгол тодотгуулагчийн харьцаатай; 2. эзэн үйлийн харьцаатай гэж ангилан үзэж болно.

2.1. Тодотгол, тодотгуулагчийн харьцаатай нэр

Монгол хүний нэрийн санд тодотгол тодотгуулагчийн (атрибутив) харьцаатай нийлмэл нэр өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд монгол хэлний холбоо үг бүтээх хамжуулах арга, найруулах аргаар бүтсэн байдаг. Нийлмэл нэрийн бүрэлдэхүүнд орж байгаа хоёр үгийг хэл зүйн ямар ч нөхцөл, дагавар хэрэглэлгүй зөвхөн тогтмол байршлын аргаар хооронд нь холбон үүсгэсэн нэрийг хамжуулах аргаар бүтсэн, тодотгол тодотгуулагчийн харьцаатай нэр гэж үзлээ. Эдгээр нэр ихэвчлэн тэмдэг нэр + нэр үг, тооны нэр + нэр үг, үйл үг + нэр үг гэсэн бүтэцтэй байгаа бөгөөд нийлмэл нэрийн эхний хэсэгт орсон үгс нь II хэсэгт орж байгаа нэр үгээ тодотгон, түүний өнгө зүс, чанар, байдал, тоо хэмжээг илэрхийлсэн утгатай байна. Жишээлбэл: Алтанчимэг, Борбаатар, Гүндалай, Анхбаяр, Дэлгэрэхцэцэг, Малчинхүү, Мөнгөнтуяа, Түмэннасан, Бат-Амьдрал гэх мэтийн олон нэрийг дурдаж болно. Эдгээр нэрийг хэлзүйн талаас нарийн ажиглавал эхний үг нь дараах үгээ тодотгосон тодотголын үүрэгтэй байгаа нь төвөггүй мэдэгдэнэ. Өөрөөр хэлбэл: 'Алтан чимэг, Бор баатар, Гүн далай, Анх баяр, Дэлгэрэх цэцэг, Малчин хүү, Мөнгөн туяа, Түмэн насан, Бат амьдрал гэх мэт. Тодотгол тодотгуулагчийн харьцаатай нийлмэл нэрийг захирагдсан үгэнд нь ямар нэгэн нөхцөл, дагавар залгаж тухайн хоёр үгийн хоорондох хэл зүйн харьцааны утга санааг илэрхийлдэг, найруулах аргаар бүтээж бас болдог байна. Үүнд:

а) Захирагдсан үгэнд нь харьяалахын тийн ялгалын **-ын, -ийн, -н, -ны, -ний** нөхцөл залгаж дараах үгэнд нь тодотгол болгосон шинжтэйгээр нийлмэл нэр үүсгэдэг байна. Жишээ нь: *Анхныбаяр* (анх+ны+баяр), *Үүрийнтуяа* (үүр + ийн + туяа), *Үүрийнцэцэг* (үүр + ийн + цэцэг), *Хилийнбаатар* (хил + ийн + баатар), *Шинийннэгэн* (шинэ + ийн + нэгэн), *Алсындаваа* (алс + ын + даваа), *Хадны-Өвгөн* (хад + ны + өвгөн), *Огторгуйндалай* (огторгуй + н + далай), *Ойнчимэг* (ой + н + чимэг), *Ойнбаяр* (ой + н + баяр), *Ханийнжаргал* (хань + ийн + жаргал), *Шөнийндүү* (шөнө + ийн + дүү), *Шинийнсар* (шинэ + ийн + сар), *Үүрийнцолмон* (үүр + ийн + цолмон), *Үдийннаран* (үд + ийн + наран), *Түмнийманлай* (түмэн + ий + манлай), *Ирээдүйнбаяр* (ирээдүй + н + баяр), *Хангайннуруу* (хангай + н + нуруу), *Цэргийнхүү* (цэрэг + ийн + хүү), *Анхнытуяа* (анх + ны + туяа), *Талынцэцэг* (тал + ын + цэцэг), *Хилийнцэцэг* (хил + ийн + цэцэг), *Анхнысувд* (анх + ны + сувд), *Талынбаатар* (тал + ын + баатар), *Ургацындалай* (ургац + ын + далай), *Хүнийхүү* (хүн + ий + хүү), *Эрдмийндалай* (эрдэм + ийн + далай), *Говийнбаатар* (говь + ийн + баатар), *Говийнцэцэг* (говь + ийн + цэцэг), *Далайнцэцэг* (далай + н + цэцэг), *Минийнаран* (би + ний + наран), *Минийхүү* (би + ний + хүү), *Номынбаясгалан* (ном + ын + баясгалан), *Огторгуйнтуяа* (огторгуй + н + туяа), *Өдрийн-од* (өдөр + ийн + од), *Сарныгэрэл* (сар + ны + гэрэл), *Үүрийнжаргал* (үүр + ийн + жаргал), *Үүрийнсаран* (үүр + ийн + саран), *Алтайн-Эрдэнэ* (Алтай + н + эрдэнэ), *Алтайнхүү* (Алтай + н + хүү), *Анхныжаргал* (анх + ны + жаргал), *Анхныцас* (анх + ны + цас), *Анхнызулцэцэг* (анх + ны + зул + цэцэг), *Анхныгалцэцэг* (анх + ны + гал + цэцэг), *Ардынжаргал* (ард + ын + жаргал), *Байнгынжаргал* (байнга + ын + жаргал), *Баярынмэнд* (баяр + ын + мэнд), *Билгийндалай* (билиг + ийн + далай), *Гэрийнчимэг* (гэр + ийн + чимэг), *Говийнчулуу* (говь

+ ийн + чулуун), *Далайнхүү* (далай + н + хүү), *Лусынхүү* (лус + ын + хүү), *Жаргалынтуяа* (жаргал + ын + туяа), *Эхорнынэгөглөө* (эх + орон + ы + нэг + өглөө) гэх мэт.

б) Өмнөх үгэнд нь үг бүтээх -т, -тай, -тэй хэмээх дагавар залган тодотгол тодотгуулагчийн харьцаатай нийлмэл нэр бүтээдэг. Жишээ нь: *Цогтбаяр* (цог + т + баяр), *Гэрэлт-Од* (гэрэл + т + Од), *Зоригтбаатар* (зориг + т + баатар), *Хүчитбаатар* (хүч + т + баатар), *Азтайбаяр* (аз + тай + баяр), *Гэрэлт-Од* (гэрэл + т + од), *Гэрэлттагтаа* (гэрэл + т + тагтаа), *Гэрэлттор* (гэрэл + т + төр), *Галтболд* (гал + т + болд), *Цогтгэрэл* (цог + т + гэрэл), *Алдартбаатар* (алдар + т + баатар), *Алдартхүү* (алдар + т + хүү), *Хишигтхүү* (хишиг + т + хүү), *Хүндэтбаатар* (хүндэт + т + баатар), *Энэрэлтхүү* (энэрэл + т + хүү), *Түүхтбаяр* (түүх + т + баяр), *Азтайхүү* (аз + тай + хүү), *Бадралттор* (бадрал + т + төр), *Баяртцэцэг* (баяр + т + цэцэг), *Баярт- Ирээдүй* (баяр + т + ирээдүй), *Гэрэлт-Ирээдүй* (гэрэл + т + ирээдүй), *Баясгалант-Амьдрал* (баясгалан + т + амьдрал), *Галтайхүү* (гал + тай + хүү), *Жаргалтайбаатар* (жаргал + тай + баатар), *Ивээлтнаран* (ивээл + т + наран), *Баяртайхүү* (баяр + тай + хүү), *Гантайхүү* (ган + тай + хүү) гэх мэт.

в) Өмнөх үгэнд нь үгүйсгэх утгатай «-гүй» бүтээвэр залган мөн энэ төрлийн нийлмэл нэр үүсгэсэн байна. Жишээ нь: *Аймшиггүйбаатар* (аймшиг + гүй + баатар), *Алзахгүйбаатар* (алзах + гүй + баатар), *Осолгүйгэрэл* (осол + гүй + гэрэл), *Олдошгүйбаяр* (олдош + гүй + баяр), *Нэргүйцэцэг* (нэр + гүй + цэцэг), *Нэргүйхүү* (нэр + гүй + хүү), *Гандашгүйцэцэг* (гандах + гүй + цэцэг), *Аюулгүймөнх* (аюул + гүй + мөнх), *Ажрахгүйбаатар* (ажрах + гүй + баатар), *Айлтгүйхүү* (айлт + гүй + хүү), *Мартагдашгүй-Эрдэнэ* (мартагдах + гүй + эрдэнэ), *Олдошгүй-Эрдэнэ* (олдох + гүй + эрдэнэ) гэх мэт. Ийнхүү нөхцөл, дагаврын тусламжтайгаар үүссэн нийлмэл нэрийн бүрэлдэхүүнд байгаа хоёр үгийн эхнийх нь дагавар нөхцөлийнхөө хамт ихэнх тохиолдолд хүний нэр болж чаддаггүй, зөвхөн дараагийнхаа үгтэй нийлж, түүний тодотголын шинжийг агуулан нийлмэл нэр бүтээдгээрээ хамжуулах аргаар бүтсэн нийлмэл нэрийн эхний гишүүнээс ялгагдана. Жишээлбэл: *Анхныбаяр* (Анх + харьяалахын тийн ялгалын нөхцөл + баяр), *Үүрийнтуяа* (үүр + ийн + туяа), *Үүрийнцэцэг* (үүр + ийн + цэцэг) *Гэрэлт-Од* (Гэрэл + т + Од), *Зоригтбаатар* (Зоригт + т + баатар), *Цогтбаяр* (Цог + т + баяр), *Гэрэлт-тагтаа* (Гэрэл + т + тагтаа), *Цогтгэрэл* (цог + т + гэрэл) гэх мэт.

2.2. Эзэн үйлийн (предикатив) харьцаатай нэр

Монгол хүний нийлмэл нэрийн доторхи гишүүдийн хоорондох харьцааны утгыг нарийвчлан үзвэл үйлийн эзэн, үйлийн харьцаатай буюу өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн шинжийг хадгалсан нэр цөөнгүй байна. Эдгээр нэрийг өгүүлэхүүн (предикат)-ий шинжтэй үйл үгийн хэлбэржилтийн нь байдлаар бүрэн хэлбэржсэн нэр, бүрэн бус хэлбэржсэн нэр гэж ангилан үзэж болно. Бүрэн хэлбэржсэн нэрийн өгүүлэхүүний шинжтэй үйл үг нь хэл зүйн айн талаар бүрэн хэлбэржиж өгүүлбэр төгсгөсөн шинжтэй байна. Жишээлбэл:

а) хүүрнэх өгүүлбэрийн шинжтэй нэр: *Гэрэлгарав* (Гэрэл гарав), *Майгарав* (Май гарав), *Бидялив* (Бид ялав), *Одгарав* (Од гарав), *Одонгарав* (Одон гарав), *Одгийв* (Од гийв), *Наргийв* (нар гийв) /Энэхүү Одгийв, Наргийв гэсэн хоёр нэр бол нэг айлын ихэр хүүхдүүдийн нэр юм./, *Баярбүтэв* (Баяр бүтэв), *Нарангарав* (Наран гарав), *Наргарав* (нар гарав), *Очгялбав* (Оч гялбав), *Батзорив* (Бат зорив), *Баяргарав* (Баяр гарав), *Наранмандав* (Наран мандав), *Цаннүдэв* (Цан нүдэв), *Цоггарав* (Цог гарав), *Цолмонгарав* (Цолмон гарав), *Охингарав* (охин гарав), *Туяатусав* (туяа тусав) *Эсмэдэв* (эс мэдэв), *Оюу гарав* (оюу гарав), *Шинэгарав* (шинэ гарав), *Гэрэлцацрав* (гэрэл цацрав) гэх мэтээр нийлмэл нэрийн сүүлчийн гишүүн нь үйл үгийн өнгөрсөн цагийн -в нөхцөлөөр хэлбэржсэн нэр их байгаагийн дотор *Мягмарбадрав* (Мягмар бадров), *Мягмаржаргав* (Мягмар жаргав) гэх мэтчилэн үйлийн эзэн нь төвд нэрээс бүтсэн нэр ч тохиолдож байна. Түүнчлэн *Наранмандлаа* (Наран мандлаа), *Биирлээ* (Би ирлээ), *Хэнмэдлээ*

(хэн мэдлээ), *Хишигхүргий* (Хишиг хүргэе), *Бимэдэхгүй* (Би мэдэхгүй), *Наваан-Айсуй* (Наваан айсуй) гэх мэтээр сүүлчийн гишүүн нь янз бүрээр хэлбэржиж бас болдог байна.

б). Асуух өгүүлбэрийн шинжтэй нэр: *Хэнбээ* (хэн бэ?), *Хэнбилээ* (хэн билээ?), *Тэрхэнбээ* (тэр хэнбэ?), *Юувээ* (Юу вэ?), *Юубилээ* (юу билээ?), *Амарсайнуу* (амар сайн уу?), *Амарбайнуу* (амар байна уу?), *Хэнмэдэхэв* (Хэн мэдэх вэ?), *Хэнбилээ* (Хэн билээ?), *Нэрхэнбээ* (нэр хэн бэ?), *Юүгэв* (юу гэв?), *Хэнчюмбэ* (Хэн ч юм бэ?), *Мэндүү* (Мэнд үү?), *Отгонбиз* (Отгон биз) гэх мэтээр ихэвчлэн асуух сул үг оролцон бүтсэн байдаг.

в). Захирах хүсэх өгүүлбэрийн шинжтэй нэр: *Баярсонсго* (баяр сонсго), *Мөнхжарга* (мөнх жарга), *Мөнхнасал* (мөнх насал), *Бат-орш* (бат орш), *Мөнх-оршиг* (мөнх оршиг), *Төвшинжарга* (төвшин жарга), *Энхжарга* (энх жарга), *Эрдэнэдүүр* (эрдэнэ дүүр), *Нарангий* (наран гий), *Одбарь* (од барь), *Дүүдагуул* (дүү дагуул), *Буяндагуул* (буян дагуул), *Төрмандуул* (төр мандуул), *Мөнхмандуул* (мөнх мандуул), *Наранмандуул* (наран мандуул), *Өлзийбүрд* (Өлзий бүрд), *Өлзийбүт* (Өлзий бүт), *Буянирэг* (буян ирэг), *Мөнхзогс* (Мөнх зогс), *Цогбадар* (Цог бадар), *Цэрэгбайя* (Цэрэг байя), *Хүнд-Өргүүл* (Хүнд өргүүл), *Маамаагээрэй* (маамаа гээрэй), *Большүү*, *Большоль* гэх мэтээр нийлмэл нэрийн сүүлчийн гишүүн (үйл) нь үйл үгийн захирах хүсэх хэлбэрийн нөхцөлөөр хэлбэржсэн байдаг.


г). Үгүйсгэх өгүүлбэрийн шинжтэй нэр: *Хэнчиши* (хэн ч биш), *Бибишхорлоо* (Би биш хорлоо), *Бишээхүү* (Бишээ хүү), *Урьдынбиши* (урьдынх биш), *Хэнчмэдэхгүй* (хэн ч мэдэхгүй), *Огтбиши* (Огт биш), *Огтмэдэхгүй* (огт мэдэхгүй), *Нэрбайхгүй* (нэр байхгүй), *Бимэдэхгүй* (би мэдэхгүй), *Алнчиши* (аль нь ч биш), *Басалбиши* (бас л биш) гэх мэтээр үгүйсгэх сул үг оролцуулан бүтсэн байдаг.

Энэбиши, *Тэрбиши*, *Басбиши*, *Бибиши*, *Чибиши*, *Тиймбиши* (тийм биш), *Цэцэгбиши* (цэцэг биш), *Хүнбиши* гэх мэтийн нэрийг ихэвчлэн хүүхэд нь тогтодоггүй айл түрүүчийн үрэгдсэн хүүхэд биш, өөр юм гэсэн санаагаар, эсвэл хүү хүсдэг айлд охин төрөх, охин хүсдэг айлд хүү төрөх зэрэг тохиолдолд үгүйсгэсэн утгаар өгдөг байна. Иймд эдгээр нэрийг бүтээж буй үгс нь ямар нэгэн юм биш, өөр юм гэсэн утга хадгалсан заримдаг өгүүлбэрийн шинжийг хадгалж байна гэж үзэж болно. Эдгээр нэрэнд нэг юмыг үгүйсгээд оронд нь юу болохыг нь хэлээгүй (0 хэлбэртэй байгаа) боловч лав л өөр юм байна гэдэг нь мэдэгдэж байна. Тэгвэл *Энэбишчулуун*, *Хүнбишгөлөг* зэргийн нэрэнд түрүүчийнхийг нь үгүйсгээд оронд нь юу болохыг нь хэлсэн учир утга бүрэн төгссөн өгүүлбэрийн шинжийг хадгалсан нь тодорхой харагдаж байна.

д). Батлах өгүүлбэрийн шинжтэй нэр: *Наранмөн* (Наран мөн), *Мядагмөн* (Мядаг мөн), *Мөнхбайна* (Мөнх байна), *Цоожбат* (цоож бат), *Мөнбайна* (Мөн байна), *Хийморьсайн* (хийморь сайн) гэх мэтээр батлах сул үг болон мөн, байна гэдэг үйл үгийг оролцуулан бүтсэн байхаас гадна үйл үгээс өөр аймгийн үгээр бүтсэн ч гэсэн утгын хувьд батлах, нотлох санаа илэрхийлж буй олон нэрийг энэ хэсэгт хамааруулан үзэж болох юм. Жишээ нь: *Жаргалсайхан* (Жаргал сайхан), *Баярсайхан* (Баяр сайхан), *Цэцэгсайхан* (Цэцэг сайхан), *Хүнсайхан* (хүн сайхан), *Амьдралсайхан* (амьдрал сайхан), гэх мэт. Энд дурдсан *Баярсайхан*, *Жаргалсайхан*, *Хишигбат*, *Төрмөнх* гэх мэтийн олон нэрийг бүтээж буй үгс нь хоорондоо өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүний харьцаатай байж, нэрлэсэн өгүүлбэрийн шинж чанарыг хадгалж байна. Харин эдгээр нэрэнд үгсийн байрыг *Сайханжаргал*, *Батхишиг*, *Мөнхтөр*, *Сайханбаяр* гэж соливол тодотгол тодотгуулагчийн харьцаатай холбоо үг болж өөрчлөгдөнө. Бүрэн бус хэлбэржсэн өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүний шинжтэй нийлмэл нэр нь *дор дурдсан хоёр үндсэн онцлогтой байна*.

1. Нийлмэл нэрийн II хэсэгт өгүүлэхүүний үүргээр орж буй үйл үг нь зөвхөн үйлт нэрийн «х» дагавартай хэрэглэгдэх бөгөөд бүрэн утга төгссөн өгүүлбэрийн утгыг илэрхийлж чаддаггүй. Жишээ нь *Зоригбадрах* (Зориг бадрах), *Баяртогтох* (Баяр тогтох), *Буян-Арвижих* (Буян арвижих), *Галмандах* (Гал мандах), *Цогнэмэх* (Цог нэмэх) гэх мэт.

2. Нийлмэл нэрийн II хэсэгт өгүүлэхүүний үүргээр орсон нэр нь үйл үгээс бусад аймгийн үгсээр, тухайлбал тэмдэг нэрээр бүтсэн байдаг. Жишээ нь: *Нарантунгалаг* (Наран тунгалаг), *Цэцэгдэлгэр* (Цэцэг дэлгэр), *Оюундэлгэр* (Оюун дэлгэр) гэх мэт. Эдгээр нэрийн доторхи үгсийн байрыг соливол тодотгол тодотгуулагчийн харьцаатай болж утга нь өөрчлөгдөнө. Жишээ нь: *Бадрахзориг* (бадрах зориг), *Тогтохбаяр* (тогтох баяр), *Арвижихбуян* (арвижих буян), *Тунгалагнаран* (тунгалаг наран), *Дэлгэрцэцэг* (дэлгэр цэцэг), *Дэлгэр-Оюун* (дэлгэр оюун) гэх мэтийн нэр болон өөрчлөгдөнө. Энэ бүхнийг бүдүүвчээр үзүүлбэл:



Эдгээр баримтаас үзвэл :

1. Нэгэн хүнийг нэрлэн заах дохио болгон хэрэглэж байгаа хүний нэрийн үгийн сангийн үндсэн утга нь хүмүүсийн харилцааны хүрээнд ямар нэг үүрэггүй боловч түүнийг бүтээж буй материал болох үг, холбоо үг нь тухайн хэлнийхээ хэл зүй, утга зүйн шинж чанарыг бүрэн хадгалж байна.

2. Монгол хэлний үгээс нийлмэл нэр үүсэхдээ холбоо үг бүтэх хуулийн дагуу үүсдэг бөгөөд тэдгээрийн гишүүд хоорондоо атрибутив (тодотгол тодотгуулагч), предикатив (өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн) харьцаатай байна. /Ж.Сэржээ 1992.28-32-р тал/

3. Нэрийтгэл нэрээс оноосон нэр болж буй бүтээврийн утга агуулга эрс

өөрчлөгддөг нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл дээр дурдсан нэрсийн дотор байгаа харьяалахын тийн ялгалын -ын, -ийн, -н нөхцөл хүний нэрэнд орохдоо үг бүтээх дагаврын үүрэг гүйцэтгэсэн байна. Энэ үзэгдлийн талаар ОХУ-ын нэр зүйч А. Г. Митрошкина “Үг бүтээх дагавар, тийн ялгалын болон үйл үгийн хэлбэрийн нөхцөлүүд нь хүний нэрийн системд хүний нэр бүтээх бүтээвэр шиг шинэ үүрэг гүйцэтгэдэг” гэжээ /А.Г.Митрошкина. 1967. 55-р тал/

Ж.Сэржээ

ЭШ ТАТСАН НОМ ЗОХИОЛ

1. Митрошкина А.Г.(1967). Морфологическая структура исконных бурятских личных имен и семантика их апеллятивов. В кн. "Ономастика Бурятий" Улан-Удэ.
2. Розенталь Д.Э.,ТеленковаМ.А. (1985). Словарь-справочник лингвистических терминов. Москва
3. Сундуева Е.В.(2005). Проприальное словообразование в современном монгольском языке. Улан-Удэ.
4. Суперанская А.В. (1969). Структура имени собственного /фонология и морфология/. Москва.
5. Сэржээ Ж. (1992). Монгол хүний нэр. Улаанбаатар.

LINGUISTIC METHODS CREATING PERSONAL NAMES IN MODERN MONGOLIAN

Most of Modern Mongolian names are compound names consisting of two words. The two words that create the compound names are composed in the following ways.

1. Coordinative word-combination
2. Subordinate word-combination

In this article, studying the meanings of the words belonging to the latter, the author has classified it in the following categories.

- a. Names with attributive relation which modify each other
- b. Names with predicative relation

Also the author has tried to confirm it by the facts.